



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг батлах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тогтвортой хөгжлийн зорилгын 6.1 болон 6.2 дугаар зорилт, Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг хавсралтаар баталсугай.

2. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээний дагуу холбогдох стандартад тусгагдсан нэр, төрөл, тодорхойлолтыг шинэчлэхийг Барилга, хот байгуулалтын яам /Х.Баделхан/, Стандарт, хэмжил зүйн газар /Б.Билгүүн/-т зөвлөмж болгосугай.

3. Хавсралтаар батлагдсан Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг мөрдөж ажиллахыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /Ж.Батсуурь/-д зөвлөмж болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал баталсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 1/4 дүгээр "Төрөл батлах тухай" тушаалыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.АРИУНЗАЯА

000849

ҮСХ-ны даргын 2019 оны 1 дүгээр сарын 19-ний
өдрийн .11/15 дугаар тушаалын хавсралт



УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ

Улаанбаатар хот
2019 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ЗОРИЛГО.....	3
ГУРАВ. УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ.....	4
3.1. УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН НЭР, ТӨРӨЛ.....	4
3.1.1. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрийн нэр, төрлийн тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр.....	4
3.1.2. Шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэрийн нэр төрлийн тодорхойлолт	5
3.2. АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРӨЛ.....	6
3.2.1 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн нэр төрлийн тодорхойлолт.	6
3.2.2 Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжийн нэр төрлийн тодорхойлолт	8
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

MNS	Mongolian national Standard
SDG	Sustainable Development Goals
ТХ	Тогтвортой хөгжил

УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Ус, ариун цэврийн хүртээмж нь нийгэм, эдийн засгийн болон эрүүл ахуйн нөхцөл байдлыг илэрхийлэх гол илтгэгч гэж тооцогдох бөгөөд эх хүүхэд, гэр бүлийн эрүүл мэнд, амьдралын чанар болон нийгмийн үр бүтээмжийг илтгэх чухал үзүүлэлт юм.
- 1.2. Хөдөө орон нутаг, малчдад зориулсан унд ахуйн усны хангамж хүртээмж муу, сум хот суурин газарт усны чанар, хүртээмжийн асуудал хангалтгүй, хөдөө орон нутагт ил задгай бие засах, гэр хорооллолд шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж ашиглаж буй хүн амын тоо буурахгүй байгаа нь ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна.
- 1.3. Тогтвортой хөгжлийн зорилго 6 нь Бүх нийтийг аюулгүй ундны ус, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай, ус, ариун цэврийн тогтвортой менежментийг хангахад чиглэгдсэн. Монгол Улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах тогтвортой үйлчилгээгээр хангахад анхаарч байна.
- 1.4. Тогтвортой хөгжлийн зорилго 6.1 болон 6.2 дугаар зорилгын хэрэгжилтийг дүгнэхдээ ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, хүртээмжээс гадна үйлчилгээний түвшинг шатлалтайгаар үнэлэх шинэ зарчмыг мөрдөх болсон. Үүнтэй уялдуулж шалгуур үзүүлэлтийг тооцох, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахад энэхүү ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг баримтална.
- 1.5. Үндэсний хэмжээнд Тогтвортой хөгжлийн зорилго 6.1 ба 6.2 –ын хэрэгжилтийг үнэлэх арга зүйг боловсруулахад эхний ээлжинд ус хангамжийн эх үүсвэр болон ариун цэврийн байгууламжийн шаардлага хангасан ба шаардлага хангаагүй нэр, төрлийн үзүүлэлтийг олон улсын арга зүйн ангилалд нийцүүлэн баталж, мөрдөх нь энэхүү баримт бичгийн нийтлэг үндэслэл болно.

ХОЁР. ЗОРИЛГО

- 2.1 Энэхүү нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, эрүүл ахуйн нөхцлийг тодорхойлох, үнэлэх, дүгнэхэд баримтална.
- 2.2 Тогтвортой хөгжлийн зорилго 6-тай уялдуулан Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалд тусгах ус хангамжийн эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн шаардлага хангасан болон шаардлага хангаагүй нэр, төрлийн үзүүлэлтийг тодорхойлоход оршино.
- 2.3 Хүн амын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаар холбогдох байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтээр тоон мэдээллүүдийг гаргах, мэдээллийн урсгалыг зөв, оновчтой зохион байгуулах, цаашид үндэсний хэмжээнд нэгдсэн нэр төрлөөр тодорхойлох, Тогтвортой хөгжлийн зорилгуудын биелэлтийг хангах, бодитой үнэлэхэд оршино.

ГУРАВ. УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ

Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээ нь нь дараах 4 бүлэгтэй байна. Үүнд:

1. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрийн нэр, төрөл
2. Шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэрийн нэр, төрөл
3. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн нэр, төрөл
4. Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжийн нэр, төрөл зэрэг орно.

3.1. УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН НЭР, ТӨРӨЛ

Ус хангамжийн эх үүсвэрийн тодорхойлолт: Худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг ойлгоно.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 0900:2018 Стандартын 4.5

3.1.1. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрийн нэр, төрлийн тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр

Үзүүлэлтийн нэр, төрөл: Төвлөрсөн ус хангамж /Centralized water supply/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаа.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 5775:2014 Стандартын 4.3

Үзүүлэлтийн нэр, төрөл: Ундны ус түгээх цэг /Drinking water distribution kiosk/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хот, суурин газрын хэрэглэгчийг төвлөрсөн ус хангамжид холбогдсон болон зөөврөөр ундны усны стандартын шаардлагад нийцсэн усаар хангах үйлчилгээ үзүүлэх бүхий байр. Ус хангамжийн эх үүсвэрээр нь төвлөрсөн ус хангамжид холбогдсон, зөөврийн ус хангамжтай, гүний худгийн ус хангамжтай ус түгээх байр гэж 3 ангилна. Үүнд:

1. Төвлөрсөн ус хангамжид холбогдсон ус түгээх байр: Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах буюу түгээх шугамд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий инженерийн тоног төхөөрөмж (оролтын шугам, термометр, хаалт, эргэлтийн насос/өгөх, буцах/, агаар гаргагч, вантуз, манометр, усны тоолуур, даралт бууруулагч, хаалт, ус түгээх хоолой, халаалтын зуух буюу халаах цогц төхөөрөмж)-тэй угсрагдсан байр./ MNS 5775:2014 стандартын 4.5/
2. Зөөврийн ус хангамжтай ус түгээх байр: Ундны усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөн, ус түгээх байрны ус нөөцлүүрт хуримтлуулан, хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий инженерийн тоног төхөөрөмжтэй ус түгээх байр.

3. Гүний худгийн ус хангамжтай ус түгээх байр: Гүний худгаас усыг олборлон, стандартын шаардлагад нийцүүлэн, хэрэглэгчдэд түгээх зориулалт бүхий инженерийн тоног төхөөрөмжтэй ус түгээх байр.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 5775:2014 Стандартын 4.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Худаг /Well/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Газрын хэвлий дэх усыг ашиглах зорилгоор уурхайлан ухаж, ханыг нуралтаас хамгаалах хашлага болон шүүрээр тоногдсон, усыг газрын гадаргад өргөх ховоо, насос бүхий усны менежментийн байгууламж. Өрөмдмөл, богино яндант, уурхайн /бетон хашлагат/, энгийн уурхайн гэх мэт төрөлтэй.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6694:2017 Стандартын 455

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хамгаалсан гар худаг /Protected dug well/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гадаргын урсац худагт орохоос сэргийлж өндөрлөсөн, бетон бүүрэг, мал, амьтан, хог унахаас хамгаалсан ам таглаа бүхий худаг

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.3.5

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хамгаалсан булаг /Protected springs/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гаднын нөлөөнд автах гадаргын урсац орохоос хамгаалж тоосго буюу бетон хийцээр битүүлсэн ус авах зориулалтын хоолой болон ариун цэврийн хамгаалалтын бүс бүхий усны эх үүсвэр

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.3.4

Үзүүлэлтийн нэр, төрөл: Савласан ус /Bottled water/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Байгалийн гүний, гадаргын болон төвлөрсөн усан хангамжаас эх үүсвэртэй технологийн тодорхой боловсруулалт хийж, хүний ундны хэрэглээнд шууд хэрэглэх зориулалтаар боловсруулсан ус

Мэдээллийн эх үүсвэр: MNS 5007: 2007 Стандартын 4.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Зөөврийн усны үйлчилгээ /Tanker-truck/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Усыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээж борлуулах үйлчилгээ

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.4.1

3.1.2. Шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэрийн нэр төрлийн тодорхойлолт

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хамгаалаагүй гар худаг /Unprotected dug well/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Дараах нөхцөлтэй байвал хамгаалаагүй гар худаг гэж үзнэ. Үүнд:

- Худагт гадаргын урсац орохоос хамгаалаагүй.
- Худагт мал, амьтан, хог унахаас хамгаалах ам таглаа муутай.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.4.6

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хамгаалаагүй булаг /Unprotected springs/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гадаргын урсацаас болон гадны бохирдлоос хамгаалж битүүлээгүй мал, амьтан орох боломжтой булаг

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.4.5

Үзүүлэлтийн нэр, төрөл: Ус зөөврийн ердийн хөсөг /Cart with small tank/drum/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ус зөөврийн зориулалтын авто тээврээс бусад төрлийн ус зөөх хөсөг. Энэ нь усыг үхэр, морь, тэмээн тэрэг болон бусад төрлийн хэрэгслэлээр зөөвөрлөн түгээх үйлчилгээг гүйцэтгэнэ.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.4.3

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хурын ус /Rainwater/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Бороо, цасны усыг дээвэр ба газрын гадаргуугаас цуглуулж, нөөцлүүрт хадгалсан ус.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.3.6

Үзүүлэлтийн нэр, төрөл: Усны ил эх үүсвэр /Surface water/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гол мөрөн, нуур, тойром, цөөрөм, голын салаа, татуурга болон усалгааны сувгаас шууд авсан ус

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 4.4.4

Ус хангамжийн хүртээмжийг тооцохдоо: Ундны усны эх үүсвэрийн хамрах хүрээ, үйлчилгээний хүртээмж, ундны ус авах цэгийн байршил, ус авахад зарцуулах хугацаа зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан ус хангамжийн үйлчилгээний хамрах хүрээ нь ус авах цэг 200 метр хүртэл радиуст үйлчлэх буюу ус авахдаа 30 минутаас бага хугацаа зарцуулах байдлаар тооцно.

3.2. АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭР, ТӨРӨЛ

Ариун цэврийн байгууламжийн тодорхойлолт: Хүрээлэн буй орчин болон нийгмийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бохир усыг зайлуулах найдвартай, иж бүрэн системийг хэлнэ. Үүнд: хүний ялгадас, мал амьтны өтөг, шивх, хатуу ба шингэн хог хаягдлыг зайлуулах зэрэг ажиллагаа багтана. / MNS 6279:2011 стандартын 5.1/

3.2.1 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн нэр төрлийн тодорхойлолт

Үзүүлэлтийн нэр, төрөл: Ариутгах татуурга /Sewerage/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хэрэглээнээс гарсан бохир усыг гадагшлуулах, цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 5.2

Үзүүлэлтийн нэр, төрөл: Битүү тунгаагуур /Septic tank/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуур. Тунасан лагийг юулж цэвэрлэнэ.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 5.3.4

Үзүүлэлтийн нэр, төрөл: Угаадасны нүх /Soak pit/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзэлхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлуулах, шаардлага хангасан хийц бүхий байгууламж.

Мэдээллийн эх үүсвэр: Нүхэн жорлон, угаадасны нүх. MNS 5924:2015 стандартын 4.2

Үзүүлэлтийн нэр, төрөл: Нүхэн жорлон /Pit latrine/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тав тухтай орчинд бие засах зориулалт бүхий хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзэлхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулах шаардлага хангасан хийц бүхий байгууламж. Үүнд:

1. **Хагас нэвчилттэй жорлон, угаадасны нүх:** Энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан нэг удаа ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж / MNS 5924:2015 стандартын 4.3/
2. **Нэвчилтгүй жорлон, угаадасны нүх:** Хүчитгэсэн доторлогоотой, тооцоолсон эзэлхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан давтан ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж / MNS 5924:2015 стандартын 4.4/

Мэдээллийн эх үүсвэр: Нүхэн жорлон, угаадасны нүх. MNS 5924:2015 стандартын 4.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Бохир усны цооног /Pumped Holding Tank/
/Стандартад тусгуулах шаардлагатай/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хүчитгэсэн доторлогоотой, тооцоолсон эзэлхүүнтэй, бохир усыг цуглуулан автомашинаар соруулж, зөөвөрлөх боломжтой байгууламж (ханаар бохир ус хөрсөнд нэвчихгүй)

Мэдээллийн эх үүсвэр: Стандарт боловсруулах шаардлагатай.

Үзүүлэлтийн нэр, төрөл: Био жорлон /Compost toilet/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногоо хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсыг үнэргүй, гэм хоргүй бордоо болгох хуурай жорлон.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 5.3.2

3.2.2 Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжийн нэр төрлийн тодорхойлолт

Үзүүлэлтийн нэр, төрөл: Задгай жорлон /Pit latrines without a slab/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тавцан нь хүчитгэсэн болон энгийн хавтангүй, нүх дүүргэлтийн хугацаанд ашиглах, хөрсөнд шингээдэг жорлон.

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 стандартын 5.4; Integrated Monitoring Guide for SDG 6 Step-by-step monitoring methodology for 6.3.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Ил задгай бүхээгтэй жорлон /Hanging latrines/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Дүүжилж бэхэлсэн халхавч бүхий задгай бүхээгтэй, бохир нь байгальд шингэдэг жорлон,

Мэдээллийн эх үүсвэр: Integrated Monitoring Guide for SDG 6 Step-by-step monitoring methodology for 6.3.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Тосох хувинтай жорлон /Bucket latrine/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ялгадсыг суултууртай хувин болон бусад төрлийн саванд хадгалж үе үе юүлж, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх нөхцөл (бордоо болгох)

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 5.4.2

Үзүүлэлтийн нэр, төрөл: Нэвчилттэй угаадасны нүх ба бусад байгууламж /Un sealed Soak pit and other facilities/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Усаар зайлуулдаг жорлон, угаадасны бохир ус нь сайжруулсан нүхэн жорлон, битүү тунгаагуур, ариутгах татуургын шугамнаас бусад байрлалд хаана нэг газар руу бохирыг урсгаж зайлуулдаг ариун цэврийн байгууламж

Мэдээллийн эх үүсвэр: Integrated Monitoring Guide for SDG 6 Step-by-step monitoring methodology for 6.3.1

Үзүүлэлтийн нэр, төрөл: Хээрийн нөхцөл /No facilities/

Үзүүлэлтийн тодорхойлолт: Бут, сөөг, ил задгай газар ба жалга, хонхорыг ашиглаж, хөрсөөр булах зэргээр (уутанд хийж хогийн саванд хийх, ус зайлуулах сувагт хаях) шууд хаях;

Мэдээллийн эх үүсвэр: MNS 6279:2011 Стандартын 5.4.1

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Савласан ус. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5007: 2007
2. Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томъёо, тодорхойлолт-тайлбар толь. MNS 6279:2011
3. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр томъёоны тайлбар толь. 2012 он
4. Ус түгээх цэгийн стандарт. MNS 5775:2014
5. Нүхэн жорлон, угаадасны нүх. MNS 5924:2015
6. Монгол Улсын ТХ-ийн үзэл баримтлал-2030
7. Хүрээлэн буй орчин. Усын нөөц.Ус ашглалт, хамгаалалт нэр томъёо тодорхойлолт. MNS 6694:2017
8. Усны чанарын стандартын эмхэтгэл. 2018 он
9. Integrated Monitoring Guide for SDG 6 Step-by-step monitoring methodology